

ТЕЛЕВИЗИЙН ОРГИЛ ЦАГИЙН НЭВТРҮҮЛГИЙН АГУУЛГЫН
ЗАРИМ ОНЦЛОГИЙН ТУХАЙД

Т.Өнөрсайхан*

* МУИС, НШУС, Сэтгүүл зүйн тэнхимийн багш, докторант

Түлхүүр үг: телевиз, оргил цаг, соёлын дайралт, үзэгч, нэвтрүүлэг, телевизийн цуврал, нийгмийн хандлага

Цаг хугацаа, орон зайн хязгаарлалтгүйгээр хүссэн бүхнээ үзэж, харах мөрөөдөл хүн төрөлхтний анхдагч түүхээс эхтэй. Эртний үлгэр домогт далдыг харагчид, ирээдүйг зөгнөгчид, шидэт толины тухай өгүүлдэг нь хүмүүсийн мөрөөдлийн нэг илэрхийлэл юм. Зуу гаруй жилийн өмнө амьдарч байсан хүний төсөөлж үл чадах тэр хүсэл өнөөдрийн бидний өдөр тутмын хэрэглээ болжээ. Технологийн хөгжлийн эрин мөрөөдлийг төсөөлөл, төсөөллийг бодит болгосноор телевиз гэсэн өвөрмөц шинжлэх ухаан, урлаг, мэдээллийн хэрэгсэл үүссэн юм. "Телевиз олон нийтийн мэдээллийн хэрэгслийн бүхэл бүтэн тогтолцоонд өөрийн зүй тогтол, хуулийн дагуу хөгжиж буй өвөрмөц, нийлэг урлаг юм"¹. Дуу, дүрсийг дохио хэлбэрт шилжүүлж, дамжуулах технологийг нээсэн эрдэмтдийг зөвхөн хэрэгсэл зохион бүтээсэн гэж тэмдэглэх нь өрөөсгөл билээ. Тэд хүн төрөлхтний хөгжлийн хандлагад нөлөөлөх нэг алхмын эхлэлийг тавьсан юм.

Анхдагч хэрэгслийг хэрэглээ болгохын тулд судлаачид бие даасан судлагдахуун бий болгож, урлагийн олон салбар ч телевизийн онцлогт тохируулан хувьсан өөрчлөгдсөөр байна. Гэхдээ телевизийн болзолт байдлуудын эцсийн гол зорилгын уулзвар нь олон түмэнд үйлчлэх юм. Ингэж телевиз хүмүүсийн өдөр тутмын амьдралд нэвтэрснээр оюун санаа, нийгмийн хандлага, зан араншин, амьдралын хэв маягт нь нөлөөлөх болжээ. "Сэтгүүл зүй нь олон нийтийн санаа бодлын "менежер, удирдаач" хэмээх утгаараа хүмүүст нийгмийн тодорхой нэг ухамсар, төлөв байдал, үнэлэмж эсвэл хандлагыг төлөвшүүлдэг. Харин тэр бүхэн нь эцсийн эцэст мэдээллийн түгээлт, дамжуулал, харьцаа зэрэг хүний амьдрал, төрөлх эрэлт хэрэгцээгээр тэжээгдэн байж, нийгмийн орчин, харилцааны тогтолцоог бий болгон төлөвшүүлдэг учиртай"² гэж доктор, профессор Б.Болд-Эрдэнэ тодорхойлсон нь бидний илэрхийлэхийг зорьж буй телевизийн онцлог юм.

Болж буй үйл явдлыг дуу, дүрсний өгүүлэмжээр олон нийтэд хүргэх нь зөвхөн дуу, чимээгээр дамжуулах, эсвэл эх бичвэрээр илэрхийлэхээс хэд

дахин хүчтэй нөлөө үзүүлдэг. Сөрөг, эерэг нөлөө үзүүлэх нь дамжуулсан мэдээллээс шалтгаалахаас гадна хүлээн авагчийн тухайн үеийн сэтгэл зүйн байдал, хандлагаас шууд хамаарна. Тиймээс телевизээр юу, хэзээ үзүүлэх вэ гэдгийг урьдчилан бодож, төвлөж гаргах нь чухал юм. Ялангуяа хамгийн олон үзэгчтэй цаг буюу бүх насныхан нэг дор цуглаж телевиз үздэг оргил цагийн хөтөлбөрийн агуулгад илүү ач холбогдол өгдөг нь олон улсын жишиг билээ.

Телевизийн хамгийн их үзэгчтэй цагийг оргил цаг (prime-time — англиар, час-пик — оросоор) гэж нэрлэдэг. Яг хэдэн цагийг оргил гэх вэ гэдгийг

тодорхойлохын тулд хүмүүсийн амьдралын хэмнэлийг мэдэх ёстой. Ихэнх дээ үзэгчид телевизийг зугаацуулах болон мэдээлэл авах хэрэгсэл гэдгээр нь ойлгож хүлээн авдаг. Тиймээс өдрийн ажлын дараа гэр бүлийн хүрээнд оройн хоолоо идэж, амрагч сонин хачин сонсож шинэ мэдээ авах, сонирхолтой хөнгөн нэвтрүүлэг үзэж ядаргаагаа тайлах зорилготой телевиз үздэг юм.

Тухайн орны амьдралын хэмнэл, онцлогоос шалтгаалж оргил цагийг хуваарилалт харилцан адилгүй байсан Олон улсын жишгээр телевизийн эфирийн цагийг дараах байдлаар хуваана.

Цаг	Хуваарилалт
6.00-10.00	Өглөөний цаг
10.00-16.30	Өдрийн цаг
16.30-19.00	Завсрын шилжих үе
19.00-20.00	Оргил цагийн эхлэл
20.00-23.00	Оргил цаг
23.00-23.30	Оргил цагийн төгсгөл
23.30-02.00	Шөнийн цаг

Орон орны амьдралын хэв маягаас шалтгаалж дээрх хуваарь нэгээс хоёр цагаар хэлбэлзэж өөрчлөгддөг. Баяр ёслолын үе, амралтын өдрүүдэд оргил цагийн хуваарилалт эсрэгээр болох нь

ч бий. Гэхдээ дэлхийн улс орнуудын амьдралын хэмнэл, дэг ерөнхийдөө төстэй учраас ажлын өдрүүдэд оргил цагийн хуваарилалт хол зөрдөггүй юм.

Орон	Цагийн хуваарилалт
Америк	19.00-23.00
	газар нутгийн онцлогоос шалтгаалж зарим мужид
	20.00-23.00
Англи	18.00-22.30
Аргентин	22.00-02.00
Грек	21.00-00.00
Индонези	18.00-23.00
Итали	21.00-23.30
Өмнөд Солонгос	20.00-23.00
Филиппин	20.00-23.00
Финлянд	21.00-23.00
Франц	20.30-22.30

Хятад	19.30-22.00
Чили	22.30-01.00
Энэтхэг	20.00-23.00
Лалын шашинтай зарим орон	02.30-04.30

Ариун сар Рамаданы үеэр телевизийн оргил цаг шөнө болдог. Нартай үед зоог барьж болдоггүй шашны онцлогоос шалтгаалж, нар жаргасны дараа гэр бүлээрээ цуглаж хоолоо хийж иддэг уламжлал нь телевизийн оргил цаг өөрчлөгдөхөд нөлөөлдөг байна.

Хамгийн олон үзэгчтэй оргил цаг телевизийн хувьд сайн нэвтрүүлгээ гаргаж үзэгчдийг татах нэг арга болдгоос гадна зар сурталчилгааны ашгаа нэмэгдүүлэх боломж юм. Бизнес эрхлэгчид бараа бүтээгдэхүүн, үйл ажиллагаагаа үр дүнтэй сурталчлахын тулд телевизийн оргил цагаар зар сурталчилгаа цацуулах сонирхолтой байдаг. Зах зээлийн хуулиар оргил цагийн ханш ч чамгүй өндөр байдаг нь дэлхий нийтийн тогтсон жишиг юм. Гэхдээ оргил цагийг ганцхан бизнесийн ашгийн хувьд харах нь учир дутагдалтай. Хэдэн цагийг оргил цаг гэх вэ? гэсэн асуултаас илүүтэй “Энэ үед юу үзүүлэх вэ?” гэдэг асуулт хамгийн их анхаарал татна. Олон улсын жишгээр оргил цагийн эфирийн ихэнх хэсгийг:

1. Телевизийн цуврал кино
2. Мэдээллийн хөтөлбөр
3. Төрөл бүрийн цэнгээнт шоу нэвтрүүлэг
4. Уран сайхны болон хүүхэлдэйн кино эзэлдэг байна.

Нэвтрүүлгийн төрөл, хэлбэрээс илүүтэй агуулгад анхаарах нь чухал. Ихэнх улсад оргил цагаар ямар агуулгатай нэвтрүүлэг гаргахыг тухайн телевизийн төдийгүй төрийн бодлогын хэмжээнд шийддэг байна. Учир нь “телевиз шууд харилцааны суваг учир олон нийтийг төөрөлдүүлж, үндэсний

хэмжээний алдаанд ч хүргэж болзошгүй аюултай”³ хэрэгсэл юм. Нөгөө талаар үзэгчдийн боломжит тоон хэмжээ эрс нэмэгдсэн цагаар олон нийтийн санаа бодолд зэрэгээр нөлөөлсөн, улс орны эрх ашигт нийцтэй нэвтрүүлэг гаргаж, нийгмийн төлөвшилд зөв хандлага бий болгох зорилготой холбоотой.

Тухайлбал, Литва улсад телевизийн оргил цагаар гадаадын орчуулгын нэвтрүүлэг, кино гаргахыг хоригложээ. 18.00-22.00 цагийн хооронд зөвхөн дотоодын нэвтрүүлэг, кино гаргах шаардлагыг телевизүүдэд тавьсан байна. Энэ нь телевизээр дамжуулж гадны соёл нэвтрэхийг хязгаарлаж, үндэсний онцлогоо хадгалж үлдэх гэсэн төрийн нэгдсэн бодлоготой холбоотой юм.

Пакистан улсын Үндэсний Ассамблей дахь Мэдээлэл, радиодавтамжийн байнгын хороо телевизийн эфирийн оргил цагаар гадаадын нэвтрүүлэг гаргахыг хориглосон журам баталж, телевизийн үйлчилгээ эрхлэгчид дээрх журмыг зөрчсөн тохиолдолд хатуу арга хэмжээ авч байх санал Засгийн газартаа оруулжээ.

Украин улсын Нийтийн ёс суртахууныг хамгаалах асуудал эрхэлсэн шинжээчдийн үндэсний комиссоос (Национальная экспертная комиссия по вопросам защиты общественной

морали) "ТЕТ" телевизийг Оросын "Дом-2" реалити шоу нэвтрүүлгийг оргил цагаар гаргахыг хоригложээ. Өдөр бүр 19.30 минутаас гардаг энэ шоуны оролцогчид ёс бус хэллэг, хараалын үг хэрэглэж, хоорондоо хэрэлдэх, зодолдох зэргээр харилцааны таагүй байдал байнга гаргадаг байна. Хамгийн олон үзэгчтэй цагаар ёс зүйн асуудалтай нэвтрүүлэг гаргах нь залуучуудын хүмүүжил, ёс суртахуунд сөргөөр нөлөөлж, олон нийтийн дунд биеэ буруу авч явж болно гэсэн таагүй хандлагыг төлөвшүүлж байна гэж үзжээ.

Хятадын Радио, кино, телевизийн улсын хороо (SARFT) телевизийн эфирийн оргил цаг болох 19.30-22.00 цагийн хооронд гадаадын цуврал кино гаргахыг хориглосон байна. Оргил цагаас бусад үед гарч буй гадаадын цуврал кинонд ч хязгаарлалт хийж, ямар нэг цуврал кино гаргаж байгаа тохиолдолд 50-иас дээш ангийг нь телевизээр үзүүлэхийг хоригложээ. Телевизийн нэвтрүүлэг бэлдэж байгаа үед гадаадын киноны хэсгээс ашиглах бол нийт ашиглах материалын хугацаа 3 хүртэл минут байхаар шинэ журамд бичсэн байна. Хятадын телевизүүдээр гардаг цуврал киноны ихэнх нь Хонгконг, Өмнөд Солонгос, Тайваны кинонууд байдаг аж. Телевизийн эфирийн өдрийн цагийн төгсгөл оргил цагийн эхлэлийн хоорондох завсрын цаг ихэнхдээ 17.00-19.00 хооронд үргэлжилдэг. Хятадын эрх баригчид энэ цагт телевизээр гаргадаг хүүхэлдэйн кинонуудад ч хязгаарлалт тавьж, зөвхөн дотоодын хүүхэлдэйн кино гаргахыг үүрэг болгожээ. Ийм хязгаарлалт тогтоосноор, үндэсний кино урлаг, уран

бүтээлчдийг дэмжиж, өөрийн орны нийгэм, улс төр, уламжлал, соёлын онцлогоо залууст улам сайн таниулах зорилготой юм.

ОХУ-ын Төрийн Дума дахь Либераль-Ардчилсан намын (ЛДПР) бүлэг "Зар сурталчилгааны тухай хууль"-д нэмэлт, өөрчлөлт оруулахаар ажиллаж байна. Телевизийн эфирийн оргил цаг болох ажлын өдрүүдэд 19.00-23.00, амралтын өдрүүдэд 11.00-23.00 цагийн хооронд ямар нэгэн зар сурталчилгаа явуулах ёсгүй гэж тэд үзэж байгаа юм. Телевиз үзэгчдэд сонголт хийх боломж өгөлгүй зар сурталчилгаа хүчээр үзүүлж буй нь эрх ашгийг нь үл хүндэтгэж, ашигтай мэдээлэл авах цагийг нь бууруулж байна гэж хуулийн төслөө тайлбарлаж байна.

Олон оронд оргил цагаар гаргах нэвтрүүлгийн агуулгад хяналт тавьж, дээрх байдалтай ижил төстэй журам мөрддөг. Ингэж хяналт тавих нь хэвлэл мэдээллийн байгууллагын дотоод үйл ажиллагаанд хэт оролцож буй мэт санагдаж болох ч цаашлаад аль аль талдаа олон давхар ач холбогдолтой.

- Дотоодын кино үйлдвэрлэл, уран бүтээлчдийг дэмжих,

- Орчуулгын модон хэлнээс татгалзаж, эх хэлний яруу тансаг байдлыг хадгалсан дотоодын нэвтрүүлгээ нэмэгдүүлэх,

- Гадны соёлын дайралтаас хамгаалах,

- Уламжлалт соёлын дархлаа бий болгох,

- Эх оронч сэтгэлгээг хөгжүүлэх,

- Нийгэмд ёс суртахууны зөв хандлага төлөвшүүлэх,

- Олон нийтийн санаа бодолд эергээр нөлөөлсөн дотоодын нэвтрүүлэг

олноор гаргах боломж олгох зэрэг болно.

Дэлхий нийтийн тогтсон энэ жишиг манай улсын телевизийн салбарт дутагдаж байгаа, нэгдсэн шийдэлд хүрэх ёстой асуудал юм. Монголын телевизүүд 19.00-22.00 цагийн эфирийг хамгийн их үзэгчтэй буюу оргил цаг гэж тооцдог. Хэдийгээр гуравхан цаг мэт

боловч телевиз үзэгчид энэ хэсэг хугацаанд цэнхэр дэлгэцийг хамгийн ихээр шимтэн үздэг билээ. Өргөн нэвтрүүлгийн найман телевизийн сарын хөтөлбөрт бичил харьцуулалт хийж манай телевизүүд энэ гурван цагт ямар нэвтрүүлэг гаргаж буйг харуулахыг зорьсон юм.

Телевиз	Мэдээллийн хөтөлбөр	Дотоодын цуврал кино	Гадаадын цуврал кино	Уралдаант, цэнгээнт нэвтрүүлэг	Нийгмийн асуудал дэвшүүлсэн нэвтрүүлэг
МҮОНТ	+	+		+	+
UBS	+				+
25-р суваг	+		+		+
TB-5	+		+		
TB-9	+		+		+
NTV	+		+	+	+
Боловсрол суваг			+	+	
Монгол телевиз	+		+	+	+

Бичил судалгаанд хамрагдсан өргөн нэвтрүүлгийн найман телевизийн зургаа нь 19.00-22.00 буюу оргил цагаар гадаадын цуврал кино гаргаж байна. Эдгээр цуврал кинонууд нь Өмнөд Солонгосын “савангийн дуурь” байгаа юм. Тогтмол бусаар долоо хоногт нэгээс хоёр удаа “Боловсрол”, “Монгол” телевиз гадаадын орчуулгын цэнгээнт нэвтрүүлэг гаргаж байлаа. Энэ бүгдээс нэгтгэн дүгнэхэд манай улсад телевизийн эфирийн оргил цагийн нэвтрүүлгийн агуулгад тавьж, мөрдөх нэгдсэн бодлого дутагдаж буй нь харагдаж байна. Телевиз бол үзэгчдийн санаа бодолд шууд нөлөөлдөг хүчтэй мэдээллийн хэрэгсэл юм. Телевизээр гарсан бүхнийг үзэгчид боловсрол, нийгэмд эзлэх байр суурь, нас, хүйсийн онцлогоосоо шалтгаалж янз бүрийн “шүүлтүүрээр” хүлээн авдаг. Залуучуудын дунд Солонгосын

соёл хүчтэй нэвтэрсэн нь цуврал кино телевиз бүрийн оргил цагаар гарч байгаатай шууд холбоотой. Гэр бүлээрээ цуглаж, телевиз үзэх цагаар бүх сувгаар ижил төстэй цуврал кинонууд гарч байгаа нь үзэгчдийг ямар ч сонголтгүй, үзэхээс өөр аргагүй байдалд хүргэж байна. Үзэгч шууд бус хэлбэрээр тухайн орны оюун санааны нөлөөлөлд автаж, далд бодлого хэрэгжүүлэх гол талбар болж хувирч байгаа юм. “Ардчилал хөгжсөн орнуудад хүртэл телевиз төрийн бодлогыг хэрэгжүүлэх чухал хэрэгсэл болсоор ирсэн нь нууц бишээ”⁴. Энэ бүхэн нь үзэгчдийг гадны соёл, хэл яриа, нийгмийн байдал, цаашлаад улс төрийн бодлого шингэсэн “бүтээгдэхүүнээр угжиж” буй телевизүүдэд тавих хяналт байхгүйтэй холбоотой. Тиймээс дэлхий нийтийн жишгийн дагуу оргил цагийн нэвтрүүлгийн агуулгад төрийн

бодлогын үүднээс хяналт тавих нь олон нийтийн санаа бодолд нөлөөлж, эерэг хандлага, зөв төлөшлийг нийгэмд бий болгоход тал бүрийн чухал ач холбогдолтой юм.

Ишлэл

- ¹ Наранжаргал Х. 2006. Телевизийн сэтгүүл зүйн үндсэн ойлголт, зөвлөмж. УБ., 24 дэх тал.
- ² Болд-Эрдэнэ Б. 2009. Интернет сэтгүүл зүй. УБ., 8 дахь тал.
- ³ Наранжаргал Х. 2006. Телевизийн сэтгүүл зүйн үндсэн ойлголт, зөвлөмж. УБ., 24 дэх тал.
- ⁴ Норовсүрэн Л., Ариунзаяа Н. 2009. Телевизийн сэтгүүл зүй. УБ., 83 дахь тал.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Болд-Эрдэнэ Б. 2006. Олон нийтийн харилцаа. УБ.
2. Болд-Эрдэнэ Б. 2009. Интернет сэтгүүл зүй. УБ.

3. Зулькафиль М. 2002. Сэтгүүлчийн ур чадвар. УБ.

3. Наранжаргал Х. 2006. Телевизийн сэтгүүл зүйн үндсэн ойлголт, зөвлөмж. УБ.

4. Норовсүрэн Л., Ариунзаяа Н. 2009. Телевизийн сэтгүүл зүй. УБ.

6. Матвеев Л. В., Аникеева Т. Я., Мочалова Ю. В. 2000. Психология телевизионной коммуникации. М.

7. Цвик В. Л., Назарова Я. В. 2002. Телевизионные новости России. М.

8. Шостак М. И. 1998. Репортёр: профессионализм и этика. М.

9. Юровский А. Я. 1998. Место телевидения в системе средств массовой коммуникации. М.

Summary

The article discusses the critical analysis of Mongolian television prime-time programs. The idea of creation of prime time programs in the world television has arisen in the early 1950-s. But television in Mongolia has been created only 36 years ago. And still processing of formation modern television and programs in Mongolia.